



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/413

Булган сум

Гадаад албан томилолтын зардал  
гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын "Гадаад албан томилолтын зардлын хэмжээ шинэчлэн батлах тухай" 2011 оны 188 дугаар тушаал, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны хуралдааны Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны "Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай" IV/25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Оросын Холбооны Улсын Бүгд Найрамдах Буриад Улсын Закаменск аймагт 2026 оны 06 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд ажиллах төлөөлөгчдийн нэрсийг 1 дүгээр хавсралт, шаардагдах зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хавсралтад тусгагдсан 6,000,000 (зургаан сая) төгрөгийг Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс, 10,882,760 (арван сая найман зуун наян хоёр мянга долоон зуун жар) төгрөгийг Аймгийн Засаг даргын тамгын газраас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

А/МЗ 06 Аймгийн Засаг даргын 2026 оны  
08 дугаар сарын 08-ны/ний өдрийн  
дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт




АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРААС  
АЛБАН ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ ТӨЛӨӨЛӨЛ

д/д	Овог нэр	Албан тушаал
1	2	3
1	Дашзэвэг Эрдэнэбилэг	Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга
2	Батбаяр Эрдэнэбаатар	Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын хөгжлийн газрын хэлтсийн дарга, Орос хэлний орчуулагч
3	Сүндэв Батнасан	Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийтлэг үйлчилгээний албаны дарга
4	Гомбосүрэн Туваандорж	Аймгийн Засаг даргын Тамгын газрын жолооч

--о00о--

А/НБ 06 Аймгийн Засаг даргын 2026 оны 08 дугаар сарын 08-ны/ний өдрийн дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэг бүрийн зардал	Нийт зардал
1	Төлөөлөгчид, урлаг, спортын оролцогчдын унааны зардал	40 хүн	4 өдрийн түрээс, түлшний зардал	6,000,000
2	Аймгийн Засаг даргын тамгын газраас оролцох төлөөлөгчдийн томилолтын зардал	4 хүн 3 өдөр	210\$*3,595*4*3	9,059,400
3	Шатахуун	1760 км	352л*5180	1,823,360
Нийт				16,882,760

--o00o--